



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№60 /274/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.28

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦУГЛАРАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



“Батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудал” сэдэвт аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цуглралт өчигдөр хаалтаа хийж оролцсон бүрэлдэхүүнд талархал илэрхийлж сертификат гардуулан өглөө. Энэ үеэр Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа цуглралтад оролцсон нийт бүрэлдэхүүнд хандан зарим үүрэг, чиглэлийг өгсөн юм.

Тэрээр хэлэхдээ “2022 онд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-тай хамтран ажиллах төлөвлөгөө батлагдсан. Үүний хэрэгжилтийг сайн ханган ажиллах нь нэн тэргүүний ажил юм. Орон нутгийн удирдлагатайгаа илүү гар нийлэмжтэй ажиллах ёстой. Орон нугийн хамгаалатын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулаарай. Энэ ажлын хүрээнд

сургалтаа хэрхэн явуулах вэ гэдгийг чухалчилж үзэх хэрэгтэй. Цаашлаад Цэргийн штабуудаа бэхжүүлэх, орон тоо, нөхөн хангалтын асуудал яригдана. Аймгийнхаа цэргийн анги, салбараас тохирох бүрэлдэхүүнийг шалгаруулж нөхөн хангалтыг хийхэд анхаар. Цэргийн бэлтгэл албаны сургалтад сайтар анхаарч ажиллах шаардлагатай байна. Ямар нэгэн осол зөрчил, асуудал гарч таарахгүй. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлыг бид зайлшгүй ярих ёстой болжээ. Энэ талаар онцгой анхаарч ажиллах нь зүйтэй. Мөн нууцтай холбоотой албан бичгийг хадгалах, цэгцлэх асуудлыг сайтар анхаарах шаардлагатай. Цаашлаад хийсэн ажлаа орон нутагт сурталчлах ажилд онцгой анхаараарай” хэмээгээд нийт бие бүрэлдэхүүнд ажлын амжилтыг хүсэн ёрөөлөө.

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАГЧ БАГШИЙН ДАМЖАА ЭХЭЛЛЭЭ



Монгол хэлний тухай хуульд зааснаар “2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангахад оршино” хэмээн заасан байдаг.

Энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний 21 нэгтгэл ангийн 26 алба хаагчийг хамруулсан үндэсний бичгийн сургагч багшийн дамжаа өнөөдөр эхэллээ. Сургалтын нээлтийн ажиллагаанд БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, ЗХЖШ-ын

сургалт бэлтгэлийн газрын орлогч дарга хурандаа Гантулга нар оролцлоо.

45 хоног үргэлжлэх тус сургалтад эхний ээлжид хугацаат цэрэгтэй нэгтгэл ангиас үндэсний бичгийн анхан шатны мэдлэгтэй алба хаагчдын хамруулж байгаа бөгөөд эдгээр нь цэргийн алба хаагчид уг сургалтыг төгсөж очоод анги, байгууллагынхаа байнгын бүрэлдэхүүнээс гадна хугацаат цэргийн алба хаагчдад заах юм. Үндэсний бичгийн хичээлийг ҮБХИС-ийн ГХСТ-ийн Монгол хэл бичиг найруулгын багш, профессор Д.Болд удирдан явуулах юм.

I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ХЭЛЭЛЦЭВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл” 2022 оны I улиралд хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнав.

Хурлын эхэнд ЗХЖШ-ын ЦАХ-ийн дарга, цэргийн цагдаагийн дарга хурандаа Н.Лхагвасүрэн Зэвсэгт хүчний Жанжин штабын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-өөс энэ оны I улирлын үйл ажиллагааны тайланг танилцуулав. Зөвлөлийн төлөвлөгөөнд 5 чиглэлээр нийт 35 ажил, арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажилла төлөвлөгөөний биелэлт 96 хувьтай хэрэгжжээ.

Тухайлбал, 2021-2022 оны сургуулийн жилд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн төлөвлөгөө, сайшаал, шийтгэл, гэмт хэрэг, осол зөрчил, сахилгын хорих байранд түр саатуулагчдын бүртгэл, судалгаа зэрэг цэргийн алба, сахилга зохион байгуулалттай холбоотой хугацаат тайлан мэдээг маягтын дагуу боловсруулж сар бүрийн 20-ны дотор тайлан мэдээг ЗХЖШ-ын

Цэргийн албаны хэлтэст ирүүлэхээр албан даалгавар боловсруулан ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, “ГХУСДЖСХБСЗ”-ийн даргаар батлуулан ажиллажээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн зөвлөмж, албан даалгавар боловсруулж, ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-Инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, Байгууллагуудын салбар зөвлөлүүдэд хүргүүлж мөн ЗХЖШ-ын “ГХУСДЖСХБСЗ”-ийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, цаг үеийн холбогдолтой асуудлын саналыг зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын салбар зөвлөлүүдээс хүлээн авч хэлэлцүүлж хэвшсэн байна.

/Үргэлжлэл нь арын нүүрт/

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-2	-16


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,950.00	2,980.0
EUR	3,400.0	3,450.0
CNY	492.00	497.00
RUB	33.00	34.20
JPY	26.70	28.00
KRW	2.52	2.55

ЗУРХАЙ



2022.03.28 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Жаргал үргэлжид ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.39-19.15

Барилдлага:

РАШААН

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал: Ус

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газар яваар одогдод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,272,327 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,174,398 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,031,637 31,6%
113,896 /3,5%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8433 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
2

ЭДГЭРСЭН
8310

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 482,177,926

Эдгэрсэн

Нийт: 416,595,300

Нас барсан

Нийт: 6,148,375



Цахим шууданд

I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ХЭЛЭЛЦЭВ



татагдан ирсэн дайчдаас нөхцөл байдлын болон бие хүний түгшүүрийн байдлыг илрүүлэх, цэргийн албаны талаарх санал, сэтгэгдэл болон сургалт бэлтгэлийн чанар үр дүнг үнэлж, дүгнэх зорилгоор сургалтын анхан, дунд, төгсгөлийн шатанд авсан сэтгэл зүйн сорил, судалгааны дүнг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудаас хүлээн авч нэгтгэсэн байна. Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор

Түрүүч нь эхний нүүрт/

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаал, албан даалгавар, сэрэмжлүүлэг, цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэн, архидаан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахын тулд гэмт хэрэг, 2021 онд гарсан хөдөлмөрийн аюулгүй байдлын осол, сахилгын зөрчилд дүгнэлт хийж, 2022 оны үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдлын осол, сахилгын зөрчилд гаргуулахгүй байх талаар ЗХЖШ-ын дарга, нэгдүгээр орлогч дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нараас албан даалгавар, зөвлөмжийг Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хүргүүлэхээр ажилласан байна. Мөн "Цэргийн цагдаа-2030" хөгжлийн хөтөлбөрийн хоёрдугаар шатны 2022 онд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж шаардлагатай төсөв хөрөнгийн тооцоог БХЯ, ЗХЖШ-ын МТГ, ХЭҮК-оор уламжлуулан УИХ-д оруулахаар хүргүүлсэн бөгөөд ХЭҮК-оос Төрийн цэргийн байгууллагуудад гарч байгаа дүрмийн бус харьцааны шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааны ажлын дүнгийн хуралд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, "ГХУСДЖСХБСЗ" -ийн дарга бригадын генерал С.Ганбямба оролцож Зэвсэгт хүчний хэмжээнд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, ялангуяа төсөв, хөрөнгийн талаарх асуудлуудыг УИХ-д



танилцуулах хүсэлт гаргасан зэрэг олон ажлыг удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хийсэн байна. Гэмт хэрэг, осол, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тухайд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Батлан хамгаалахын сайдын А/336, А/71, А/ 83, ЗХЖШ-ын даргын А/535 дугаар тушаалуудыг мөрдлөг болгон гэмт хэрэг, сахилга дэг журмыг сайжруулах, урьдчилан сэргийлэх ажлуудыг хэвшил болгон ажиллаж байгаа юм. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Архидаан согтуурах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" уриалга, өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарууд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах талаар үйл ажиллагааны болон "ГХУСДЖСХБСЗ" -ийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг даалгаврын тус тус өгчээ. Мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлын тухайд Монгол Улсын хэмжээнд 2021 оны ээлжит цэрэг татлага зохион байгуулагдсантай холбогдуулан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хугацаат цэргийн албанд

ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын албаны цахим, фэйсбүүк хуудаснуудаар дамжуулан шторк, баримтат кино, зурагт хуудас, гэрэл зургуудыг нэгтгэл, ангиудаас авч "Цахим сан" байгуулах ажлыг эхлүүлжээ. Цаашид Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдын гэр бүлд, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллах зорилгоор "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гэр бүлийг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг төслөөр боловсруулан бэлтгэж, ЗХЖШ-ын даргын зөвлөлд оруулахаар бэлтгэн ажиллаж байгаа талаар танилцуулав. Хяналт шалгалт, үнэлгээний ажлын тухайд нэгтгэл, анги, байгууллагууд хэргийн гаралт, полигоны дадлагад гарах бэлтгэл болон явцад цэргийн албыг зохион байгуулж хэрэгжүүлэх байгаа ажлын төлөвлөлт, "Хэргийн байрлалд цэргийн албыг зохион байгуулах тухай" нэгтгэл, ангийн захирагчийн тушаал, бусад тушаал, шийдвэрийг анги, байгууллагын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлогтой уялдуулсан байдал, хэргийн байрлалын цэргийн албаны холбогдолтой баримт бичгийн агуулга, боловсруулалт, тэдгээрийн хэрэгжилтэд шалган туслах ажлыг явуулсан байна.

ИРГЭН ЦЭРГИЙН ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД



болон ангийн захирагчийн өрөөг үзүүлж сонирхуулахаас гадна цэргийн алба хаагчдын өдөр тутмын болон хэргийн хувцас, хэрэглэл, мэргэн буудагчийн бүлгийн талаар болон 7.62мм Драгоновын мэргэн буудагчийн винтовын үүрэг зориулалт, олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдын шалгуур, ажиллагааны өмнөх бэлтгэл, Р-107 станцыг тохируулж холбоонд орох, АКМ бууны задаргаа, угсаргаа, сумалгааны талаар

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Тус ангиас эх орны ирээдүй болсон хүүхэд багачуудад цэрэг эх оронч хүмүүжил олгох зорилгоор Завхан аймгийн Улиастай сумын "Ерөнхий боловсролын дунд сургуулиуд"-тай хамтарч орон нутагт Зэвсэгт хүчин, цэргийн анги байгууллагыг сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх ажлыг өрнүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Энэ сарын 21-ний өдөр "Элдэв-Очирын нэрэмжит Чандмань эрдэнэ лаборатори сургууль"-ийн Д.Сарангэрэл багштай 8в ангийн сурагчдад ангийн захирагч хурандаа



Г.Чулуунзагд" дайчин алдрын танхим, ахлах дэслэгч Б.Энх-Амгалан" анги үүсэн байгуулагдсан түүхэн замналыг болон үндсэн үйл ажиллагааны талаар танилцууллаа. Мөн сурагчдыг төлөвлөсөн маршрутын дагуу ангийн байр байгууламж

тус тус танилцууллаа. Мөн энэ үеэр багш Д.Сарангэрэлд ангийн захирагч хурандаа Г.Чулуунзагд баяр хүргэж дурсгалын зүйлс гардуулж, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх эрхэм үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөлөө.

Ахмад Н.МӨНХБААТАР

БОКСЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АЛДАРЫНХАН ТЭРГҮҮЛЛЭЭ



Монгол Улсын гавьяат дасгалжуулагч В.Батбаяр багшын нэрэмжит 2022 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах Боксын тэмцээн 2022 оны 3 дугаар сарын 21-27 хооронд Монгол бөхийн өргөөнд зохион байгуулагдав. Уг тэмцээнд БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооны баг тамирчид 5 алтан медаль, 6 мөнгөн медаль, 7 хүрэл медаль нийт 18-н медаль хүртэж багийн дүнгээр

1 дүгээр байрт шалгарч алтан медаль, цомын эзэд боллоо. Мөн тус тэмцээний шилдэг дасгалжуулагчаар "Алдар" спорт хорооны МУГД хошууч А.Гантулга шалгарсан бол, МУГД В.Батбаяр багшын нэрэмжит шилдэг боксчины тусгай шагналыг 51-кг-д Алтан медаль хүртсэн ОУХМ ахлагч Х.Энхмандах хүртлээ.

Үүнд, эрэгтэйчүүдийн 51кг-д ОУХМ ахлагч Х.Энхмандах, 57кг-д ОУХМ дэслэгч Х.Энх-Амар, 67кг-д ОУХМ ахлах ахлагч Б.Чинзориг, 75кг-д ОУХМ Ж.Отгонжаргал нар тус тус алтан медаль хүртсэн бол эмэгтэйчүүдийн 81кг-д А.Зейнеп алтан медаль, 50кг-д спортын мастер Н.Оюун-Эрдэнэ, мөнгөн медаль, 52кг-д спортын мастер П.Хулан, 57кг-д ОУХМ Т.Болортуул, эрэгтэйчүүдийн төрөлд 48кг-д А.Баттулга, 54кг-д Х.Билгүүнсайхан, 67кг-д МУГД У.Мөнх-Эрдэнэ, 71кг-д С.Жавхланбаяр нар тус тус мөнгөн медаль. 80кг-д спортын дэд мастер Г.Мэндбаяр, 86кг-д спортын дэд мастер М.Батбаатар, 92кг-д спортын мастер СМ Т.Ерболат, эмэгтэйчүүдийн төрөлд 54кг-д ОУХМ М.Энхжаргал, 60кг-д ОУХМ Г.Бадмаараг нар тус тус хүрэл медаль хүртлээ.

САЛААНЫ БУУДЛАГА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 124 дүгээр анги Ангийн "2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлтийн төлөвлөгөө"-ний дагуу холбоочдын тусгай тактикийн хэргийн сургууль дадлагыг зохион байгууллаа. Тус хэргийн гаралтаар офицер, ахлагч нарын дадлага ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, холбооны техник хэрэгслүүдтэй ажиллах дадлагыг нэмэгдүүлсэн,

ангийн үүрэг гүйцэтгэх боломжийг дээшлүүлсэн сургалт болсон юм. Энэ хүрээнд ангийн захирагчийн нэрэмжит нэгдүгээр үеийн төгсгөлийн амжилттай зохион байгуулж явууллаа. Мөн өнгөрөгч долоо хоногт ангийн байрлалаас Цагаан даваа-Хужирбулан-ангийн байрлал маршрутаар 30 км-ын явган маршийг зохион байгуулж Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн буудлагын талбайд "Дайсны хорлон сүйтгэх бүлэг удирдах

байр руу халдлага үйлдэх үед мотобуудлагын салааны хүчээр хориглон хамгаалах" сэдвээр салааны байлдааны буудлагыг амжилттай зохион байгуулан явууллаа. Энэ үеэр ЗХЖШ-ын цэргийн албаны хэлтсийн дарга хурандаа Н.Лхагва сүрэнгээр ахлуулсан шалган туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн төлөвлөлтийн баримт бичиг, түүний хэрэгжилт, цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй,

ковид-19 цар тахлын өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж буй байдалд шалган туслах ажлыг явуулж, салааны буудлагыг төлөвлөлтийн дагуу осол зөрчилгүй, аюулгүй ажиллагааг дээд зэргээр сахин явуулах талаар холбогдох бүрэлдэхүүнд үүрэг даалгавар, заавар зөвлөмж өгч ажилласан нь үр дүнтэй болж өгөрлөө.



Ахмад Д.ЭРДЭНЭСУВД